

Хүмүүний эрхээр хөгжил рүү!



Хүний Эрх Хөгжил Төв
CHRD

2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	3
ХЭХТ-ИЙН ТАНИЛЦУУЛГА	5
ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР	6
ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХӨТӨЛБӨР	9
ХАМТ ОЛНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР	12
ХЭХТ-ИЙН ХАМТ ОЛОН, ХАМТРАГЧИД	15
САНХҮҮГИЙН ТАЙЛАН	16

Өмнөх үг

2016 онд Монгол улсад олон чухал үйл явдал өрнөлөө. Хүний Эрх Хөгжил Төвийн хувьд боломж, сорилтоор дүүрэн он байлаа. Иргэдийн оролцоог хангах олон өөрчлөлт эрх зүйн хүрээнд бий боллоо. УИХ болон орон нутгийн сонгуулийн жил болсон тул хөгжлийн бодлогыг хүний эрхэд суурилсан болгох, тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах зорилгоор улс төрийн намуудтай харьцах шаардлага гарлаа.

Хүний Эрх Хөгжил Төвийн 2015-2018 оны стратеги зорилго нь орон нутгийн иргэдийн шийдвэр гаргахад оролцох, хэрэгжилтийг хянах, үнэлэх, хариуцлага тооцдог болох хамтын чадавхийг хөгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон. Энэ зорилгодоо 2016 онд хүрэхийн тулд гурван хөтөлбөр нэлээд үйл ажиллагаа хэрэгжүүлсэн байна.

Хүний эрхийн хамгааллын хөтөлбөр: “Хүний эрхийн хамгаалагчдын 2-р зөвлөгөөн” зохион байгуулж хүний эрхийн хамгаалагчдын сүлжээгээ өргөтгөлөө. Хүний эрхийн үндэсний механизмыг бэхжүүлэхэд ач холбогдолтой Хүний Эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны үнэлгээг хийсэн ба НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөл, Эдийн Засаг Нийгэм Соёлын Эрхийн Хорооноос өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх, зөвлөмжүүдийг тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбон ойлгодог болгох зорилт тавьж ажиллалаа. Олон улсын хүний эрхийн өдрийг нийтээр тэмдэглэдэг болгохын тулд Мөнгөн хуримтлалын бүлгүүдтэй хамтран нээлттэй цуглаан зохион байгуулж эхэлсэн. Энэ жил “Оролцооны эрхийг баталгаажуулья” сэдвээр энэ тэмдэглэлт өдрийг зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлалгүй Өвөрхангай, Дорнод, Хэнтий аймгийн төв, Сүхбаатар аймгийн сумдад Хүний Эрхийн Үндэсний Комисс, түүний орон нутгийн төлөөлөгчидтэй хамтран зохион байгуулав.

Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөр: Газар нутгаа хамгаалах орон нутгийн иргэдийн санаачлагыг дэмжин 2015 онд өрнүүлсэн кампанит ажил амжилттай болж 2016 оны 1-р сард Дорнод аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал тус аймгийн 6 сумын нутаг дэвсгэр дээрх 9 нэр бүхий газрыг улсын тусгай хамгаалалтанд авахуулах саналыг Засгийн газарт уламжлуулах шийдвэр гаргасан нь 2009 оноос эхэлсэн ажлыг амжилттай дуусгах эхний алхам боллоо. Засгийн Газар, Улсын Их Хурлаар зохих шийдвэр гаргуулж асуудлыг эцэслэх дараачийн алхамуудыг хийж байна. Энэ ажил нь орон нутгийн иргэд газар, ус, амьтан, ургамлаа хамгаалж хойч үедээ үлдээх тогтвортой хөгжлийн чухал нөхцлийг хангахаар хууль дүрмийн хүрээнд асуудлыг шийдүүлэхийг эрэлхийлсэн зарчимч үйл ажиллагаа юм. Тус хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдийг газар нутгаа хамгаалах, аж ахуй эрхлэх үйл ажиллагааг зохистой хослуулах мэдлэг, чадавхитай хүчин болгох зорилгоор сургалт, семинар, жижиг төсөлд хамруулан ажиллав.

Хамт олны хөгжлийн хөтөлбөр: Иргэдийг орон нутгийн хөгжилд идэвхитэй оролцдог, үр шимийг нь хүртдэг зохион байгуулалттай хүчин болгох үйл ажиллагаагаа өргөжүүлж байна. Энэ жил Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Дорнод аймгийн Баяндун, Дашбалбар сумдад мөнгөн хуримтлалын бүлгүүд (МХБ) шинээр байгуулагдлаа. Өвөрхангай аймгийн МХБ-д 10 жилийн ойгоо ёслол төгөлдөр тэмдэглэлээ. Энэ жилийн орон нутгийн сонгуульд мөнгөн хуримтлалын бүлгийн гишүүд идэвхтэй оролцож зарим нь сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд төлөөлөгч, тэргүүлэгч гишүүн, даргаар сонгогдлоо. Өвөрхангай, Дархан-Уул, Дорнод аймаг,

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын МХБ-дийн Холбоод өөрсдөө хөрөнгө босгож, бусдад туслах үйл ажиллагаа, сайн санааны аян зохион байгуулдаг боллоо. “Ахмадын эрхийг баталгаажуулъя” аяны хүрээнд ахмад настанд тулгамдаж буй асуудлыг хүний эрхийн өнцгөөс хөндөн гаргаж ахмадын эрхийн төлөө хамтдаа хүчээ нэгтгэн ажиллах болов.

Нийтийн эрх ашгийн клиникт хуулийн сургуулийн оюутнуудын зэрэгцээ нийгмийн ажлын оюутнуудыг элсүүлж эхэллээ. 2016 онд энэ клиникийг хууль, нийгмийн ажлаар тус бүр 3 оюутан суралцаж төгсгөв. 2016 онд Австрали, Франц, Хятад Хонг Конг зэрэг орнуудаас хууль, улс төр судлал, олон улсын харилцаагаар суралцаж байгаа нийт 6 оюутан ХЭХТ-д ирж дадлага хийлээ.


Гурван хөтөлбөрийн үйл ажиллагааны уялдаа холбоо улам бэхжиж байна. Хамт олны хөгжлийн хөтөлбөрөөр зохион байгуулагдсан МХБ, МХБХ-д хүний эрхийн хамгаалал, нөлөөллийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд идэвхитэй хамрагдаж, орон нутагт хүний эрхийн хамгаалагч болж, хүний эрхийн нөлөөллийн үйл ажиллагааг хийх хүчин болж эхэллээ.

Ази-Европ Түмний 11-р чуулганыг Монгол Улсад зохион байгуулахад Монголын иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг өргөнөөр оролцууллаа. Ялангуяа 21 аймгийн 200-аад төлөөлөгчдийг оролцуулж олон улсын иргэний нийгмийн төлөөлөгчидтэй уулзах, танилцах, суралцах, туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлж ажиллалаа.

ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВИЙН ТЭРГҮҮН



Г.УРАНЦООЖ



ТАНИЛЦУУЛГА



Хүний Эрх Хөгжил Төв
CHRD

Хүний эрх хөгжил төв (ХЭХТ) нь 1998 онд байгуулагдсан ашгийн төлөө бус төрийн бус байгууллага бөгөөд дараах гурван хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

- Хүний эрхийн хамгааллын хөтөлбөр
- Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөр
- Хамт олонд суурилсан хөгжлийн хөтөлбөр

ХЭХТ нь Монгол улсын 6 аймагт Мөнгөн хуримтлалын бүлэг байгуулан чадавхижуулж, 13 аймгийн 100-аад иргэдээс бүрдсэн Хүний эрхийн хамгаалагчдын сүлжээг зохион байгуулан ажиллаж байна.

Азийн бүсийн болон олон улсын Иргэний нийгмийн олон сүлжээ байгууллагуудад гишүүнээр элсэн хамтран ажилладаг.



ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

Үндэсний болон олон улсын бүтэц механизмыг хэрэглэн хүний эрхийн зөрчлийг арилгах, зөрчигдсөн эрхийг хамгаалах, сэргээх жишиг тогтоох зорилготой юм. Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг үнэлэх, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл болон гэрээний хороодод илтгэл хүргүүлэх, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг хийдэг.



ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХӨТӨЛБӨР

Байгаль орчин, нийтийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчинг улам сайжруулах, орон нутгийн иргэдийн оролцоог хангах зорилготой. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн иргэдийн байгаль орчин болон тэдний эрхээ хамгаалах чадавхийг бэхжүүлэх, иргэдийн үр дүнтэй оролцоог бий болгоход чиглэн ажиллаж байна.



ХАМТ ОЛНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Орлого багатай иргэдийн өөрсдийн оролцоотойгоор эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ хамгаалах, амьжиргаагаа дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, орон нутгийн хөгжилд оролцох хамтын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх зорилготой. Одоогоор 50 МХБ, 800 гаруй гишүүдтэй, 9 газар Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбоо (МХБХ), Хамт Олныг Хөгжүүлэх Сангууд (ХОХС) үйл ажиллагаа явуулж байна.



ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР



Гадаад хэргийн яам,
Зөвшилцөл танхим,
2016.11.03

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР нь стратеги зорилгынхоо хүрээнд Хүний эрхийн үндэсний бүтэц, механизмыг бэхжүүлэх, хүний эрхийн олон улсын гэрээ конвенцыг бий болгоход оролцох, үр дүнтэй хэрэглэх, хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах, иргэний нийгмийн хөгжлийн үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр дараах ажлуудыг 2016 онд амжилттай хийж гүйцэтгэлээ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2010 оны 65/182 тоот тогтоолын дагуу Насжилтын асуудлаарх НҮБ-ын Нээлттэй ажлын хэсэг байгуулагдан ахмад настны хүний эрхийг баталгаажуулах олон улсын шинэ механизмыг боловсруулахаар долоо дахь жилдээ ажиллаж байна. Энэхүү процесст Монгол улс идэвхи санаачлагатай оролцож уг конвенцын агуулгад дотоодын хуулийн үзэл баримтлалтай уялдуулсан санал өгөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах үйл ажиллагаануудыг хийсэн.



ХЭХТ ахмад настны эрхийн асуудлаар 2014 оноос ажиллаж эхэлсэн бөгөөд 2016.11.03-нд Гадаад Харилцааны Яам, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Яам, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран “Ахмад настны хүний эрхийг баталгаажуулъя” үндэсний гурван талт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



Дээрх хэлэлцүүлгээс ажлын хэсэг байгуулагдаж МУ-ын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга Д.Цогтбаатар, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, ШУ-ны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан нарт албан бичиг хүргүүлэв.



Насжилтын асуудлаарх НҮБ-ын Нээлттэй ажлын хэсэг 2016 оны 12 сарын 12-15-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо хуралдсан. Уг хуралд хүний эрхийн эксперт Д.Амарсанаа, “Хүнс эвсэл”-ийн гүйцэтгэх захирал Г.Урантүлхүүр нар оролцлоо.



2016 оны 9 сарын 15-нд “Хүний эрхийн тухай ярилцъя” өглөөний цай уулзалтыг Ахмад настны эрхийг баталгаажуулъя сэдвээр хийлээ.



Улаанбаатар хот,
Премииум палас
2016.09.14

ХАМГААЛЛЫН МЕХАНИЗМЫН АСУУДЛААРХ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ҮНДЭСНИЙ II ЗӨВЛӨГӨӨН:

Хүний эрх хөгжил төв (ХЭХТ) нь Глоб интернэшнл, Форум-Ази бүсийн байгууллагатай хамтран 2016 оны 9 сарын 14-15 нд Хүний эрхийн хамгаалагчдын 2-р зөвлөгөөнийг зохион байгуулсан. Хүний эрхийн хамгаалагчид өөрт тулгамдаж буй асуудал, бэрхшээлээ тодорхойлж, эрх ашгаа хамгаалах дотоодын бүтэц, механизм бүхий Хүний эрхийн хамгаалагчдын сүлжээг бэхжүүлэх, стратеги, төлөвлөгөөг хэлэлцэж боловсрууллаа.

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН СҮЛЖЭЭНИЙ ГИШҮҮД



ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН СҮЛЖЭЭНИЙ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ





Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан “ОРОЛЦООНЫ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛЬЯ” сэдвийн хүрээнд Хүний эрх хөгжил төв, Хүний эрхийн үндэсний комисс, Хүний эрхийн төрийн бус байгууллагын форумтай хамтран олон нийтийн цуглааныг 2016.12.10-ны өдөр 1000 гаруй хүмүүсийг, 30-аад байгууллагуудыг хамруулан Улаанбаатар хот, Дорнод, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймаг зэрэг 5 газар зэрэг зохион байгууллаа.




2016.01.17-нд Хүн худалдаалахтай тэмцэх төрийн бус байгууллагуудын сүлжээ 2 жилийн ойн баяраа тэмдэглэн өнгөрүүлсэн. ХЭХТ нь гишүүн байгууллагын хувьд ХЗДХЯ дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх дэд хорооны гишүүнээр ажиллаж, дэд зөвлөлийн 2016 онд хийх ажлын төлөвлөгөөний төсөлд санал хүргүүлэх, Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэх сургалтад оролцлоо.



2005 оноос нийтийн эрх ашгийн өмгөөллийг Монгол улсад дэлгэрүүлэх чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж 2011 оноос Нийтийн эрх ашгийг хамгаалан ажиллах ирээдүйн хуульч, бэлтгэх зорилгоор “Нийтийн эрх ашгийн клиник” /НЭАК/-ийг байгуулан иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэн ажилладаг. 2015 оноос Нийтийн эрх ашгийн Хуулийн болон Нийгмийн ажлын клиник болгон өргөжүүлж хуулийн болон нийгмийн ажлын ангийн оюутнуудыг амжилттай төгсгөөд байна.



ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХӨТӨЛБӨР



ХҮНИЙ ЭРХИЙН НӨЛӨӨЛЛИЙН ХӨТӨЛБӨР нь 2016 онд хүрээлэн буй орчин, байгалийн нөөц баялаг, экологийн үнэ цэнэтэй газар нутгаа хамгаалах, түүнд нутгийн иргэдийн үр дүнтэй оролцоог бий болгох, тэднийг чадавхижуулах сургалт, уулзалтыг зохион байгуулан холбогдох талуудад нөлөөлөх олон төрлийн ажлуудыг зохион байгуулсан.



Хөтөлбөр нь 2015 оноос эхлэн экологийн үнэ цэнэтэй газар нутгийг Улсын тусгай хамгаалалтанд авах Дорнод аймгийн иргэдийн санаачлагыг дэмжин хамтран ажилласнаар 6 сумын 9 газрыг улсын тусгай хамгаалалтанд авахыг дэмжсэн аймгийн

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолыг гаргуулж чадсан ба улмаар Засгийн газар болон УИХ-аар дэмжүүлэх нөлөөллийн ажлыг эхлүүлээд ажиллаж байна. Уг ажилд нутгийн иргэд маш идэвхитэйгээр оролцон 3032 иргэдийн гарын үсгийг цуглуулан аймгийн ИТХ, ЗГ, УИХ-д хүргүүлээд байна.

ОРОЛЦОО:

Энэхүү үйл ажиллагаа нь экологийн үнэ цэнэтэй газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах иргэдийн хүсэл эрмэлзлийг хууль журмын дагуу авч хэлэлцэж иргэдийн оролцоог бодитойгоор бий болгож буй үйл явц гэж үзэж байгаа юм.

ЧАДАВХИЖУУЛАЛТ

“ЭМЭГТЭЙЧҮҮД БА БАЙГАЛЬ ОРЧНЫ ШУДАРГА ЁС” ТӨСӨЛ

Төслийн хүрээнд ураны уурхайн ойр орчимд амьдарч буй иргэдэд нөлөөлж буй сөрөг нөлөөлөл, хүндрэл бэрхшээлийг судлан, түүнийг баримтжуулах, түүнд нөлөөлөх зорилготой нутгийн иргэдийн нөлөөллийн бүлэг байгуулан тэднийг чадавхижуулах сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ГЭРЭЭНД МОНИТОРИНГ ХИЙХ НЬ” ТӨСӨЛ

Уул уурхайн компанийн орон нутгийн захиргаатай хийсэн гэрээнд нутгийн иргэд хэрхэн мониторинг хийх, түүнд хэрхэн оролцох талаар нутгийн иргэдэд чадавхижуулах сургалтыг зохион байгуулан нөлөөллийн бүлгийн гишүүдтэй ярилцлага хийж, цаашдаа гэрээний мониторинг дээр хэрхэн ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.



Дээрх 2 төслийг Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Дорнод аймгийн Дашбалбар суманд хэрэгжүүлж байна.

Ази, Европ Түмний 11-р Чуулганыг /АЕТЧ - 11/ зохион байгуулах бэлтгэл ажил 2015 оны 10 сараас эхлэн 11 сард ОУХ-ны зөвлөмжөөр залуучууд, үйлдвэрчний эвлэл, төрөл бүрийн цөөнхийн төлөөлөл оролцож хүрээгээ тэлэн 20 орчим байгууллагаас бүрдсэн АЕТЧ-11 зохион байгуулах үндэсний хороо /ҮХ/-г байгуулж ажлын хэсэгт Л.Төр-Од, Д.Сүхгэрэл, Ж.Санчир, Б.Гүнсэн, Г.Уранцоож нар ажиллаж, ажлын албаны үүргийг Хүний эрх хөгжил төв ТББ гүйцэтгэсэн.

Улаанбаатар,
Төрийн ордны их танхим
2016.07.04



АЕТЧ-11 -ыг товлосон хугацаанд нь 2016 оны 7-р сарын 4-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо нийт 760 гаруй хүмүүс оролцоотойгоор амжилттай зохион байгууллаа. Чуулган нь ерөнхий 7 сэдвийн хүрээнд 24 салбар хуралдаан 40 орчим нийгмийн өргөн хүрээний асуудлаар хуралдсан. Чуулганд Ази, Европын 42 орны 187 гадаад төлөөлөгч, Улаанбаатар хотын 124 төлөөлөгч, 21 аймгаас 166 төлөөлөгч, Үйлдвэрчний эвлэлийн хот хөдөөгийн 114 төлөөлөгчид, засгийн газрын 10 төлөөлөгчид, үндэсний зохион байгуулагчид 22 төлөөлөгч бүхий нийт 623 оролцогчидтой чуулган боллоо. Чуулганы үеэр 72 сэтгүүлчид, 11 орчуулагчид, 21 техникийн ажилчид, 36 сайн дурын оюутнууд ажилласан. Чуулган хөтөлбөр ёсоор гурван өдөр хуралдаж чуулганы баримт бичиг болох тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан нийтээр хэлэлцэн баталж Монгол Улсын Засгийн Газрыг төлөөлөн Гадаад Харилцааны Яамны сайд Ц.Мөнх-Оргилд гардуулсан.



Улаанбаатар, Төрийн ордон
2016.07.05

АЕТЧ-11-ийг амжилттай зохион байгуулахад ГХЯ-ны Н.Анхбаяр ахлагчтай баг шаардлагатай бүх дэмжлэг, туслалцааг үзүүлсэн. Тухайлбал бэлтгэл ажлыг хангах шуурхай уулзалтуудыг хэд хэдэн удаа зохион байгуулж виз, төсөв, хурлын байр, түүний тохижилт, интернет, бүртгэл зэрэг олон тулгамдсан асуудлыг өөрийн биеэр оролцон шуурхай шийдүүлж чуулганыг амжилттай зохион байгуулахад чухал хувь нэмэр оруулсан. Мөн Төрийн Тусгай Хамгаалалтын Газрын албан хаагчид асуудалд уян хатан хандаж хамтарч ажилласан.



Ази Номхон далайн сүлжээ (APRN), Хүнсний тусгаар байдлын төлөөх хүмүүсийн эвсэл (PCFS) болон Хүний эрх хөгжил төв хамтран “Монгол дахь неолиберал даяаршил: Ардын судалгаа” арга зүйн сургалтыг 2016 оны 12 сарын 6-8 хооронд 3 хоногийн туршид Хүний эрх хөгжил төвийн сургалтын танхимд амжилттай зохион байгууллаа. Сургалтанд иргэний нийгэм, малчин, тариаланч, судлаач, төрийн зарим байгууллагын төлөөлөл болох 27 хүн хамрагдаж оролцогчид цаашид хэрэгжүүлэх судалгааны төлөвлөгөө боловсруулан, неолиберал даяаршил гэж юу болох неолиберал даяаршлын эрин үед ард иргэдэд ямар асуудлууд тулгарч байгаа, түүний эсрэг ард иргэд ямар арга хэмжээ авах талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авч, Монгол улсад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд нөлөөлөх ард түмний судалгааны арга зүйд суралцсан.



ХӨГЖЛИЙН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДЛААР: Хөгжлийн үр нөлөөг сайжруулах дэлхийн түншлэлийн хоёр дахь удаагийн мониторинг буюу улс орнуудын Пусанд өгсөн амлалтын дагуу 10 үзүүлэлтийн хэрэгжилтийг тодорхойлох мониторингийн ажилд иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) оролцох ажлыг зохион байгуулсан.

Судалгаанд Монголын иргэний нийгмийн нийт 44 байгууллагууд оролцон 10 үзүүлэлтийн иргэний нийгмийн байгууллагуудад хамаатай 1, 2, 3, 5, 7, 8 гэсэн 6 гол үзүүлэлтийн 23 асуултын хүрээнд хариулт авч судалгааг боловсруулан,

дүнг нэгтгэсэн. Мөн судалгааны дүнг баталгаажуулах болон холбогдох талуудад танилцуулах уулзалтыг зохион байгуулсан.

Судалгааны дүнг 2016 оны 11 сарын 22-нд Тайванд зохион байгуулсан Хөгжлийн үр нөлөөг сайжруулах иргэний нийгмийн түншлэлийн (ХҮНСИТ) Зүүн хойд Азийн сүлжээний хуралд танилцуулсан. Мөн энэ судалгааг ХҮНСИТ-ийн цахим сэтгүүлд нийтлүүлсэн болно.

Судалгааны үр дүн нь цаашид хийх нөлөөллийн үйл ажиллагааны зорилго, чиглэл тодорхойлох боломж олгосон.

ГАЗАР БОЛОН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ХАМГААЛАХ ДЭЛХИЙН 16 ХОНОГИЙН АЯН: 2016 оны 10 сарын 1-16-ны өдөр хүртэл үргэлжлэх “Газар болон байгалийн нөөцийг хамгаалах дэлхийн 16 хоногийн аяны хүрээнд Хүнсний тусгаар тогтнолын төлөөх эвсэлтэй хамтран зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтанд авах, үндэстэн дамнасан корпораци Монсантогийн эсрэг аяныг дэмжих зорилгоор 3500-аад хүмүүсийн гарын үсгийг цахимаар болон биечлэн цуглуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.



ХАМТ ОЛНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР




Хамт Олны Хөгжлийн Хөтөлбөр нь иргэдийн өөрсдийн оролцоотойгоор ядуурлыг буруулах, орлого багатай иргэдийн ЭЗНСЭ-ийг хамгаалах, хамтын үйл ажиллагааг дэмжиж, орон нутгийн хөгжилд оролцоог хангах замаар амьжиргааг дээшлүүлэх, тэдний хөгжлийг дэмжих зорилготой юм.

МӨНГӨН ХУРИМТЛАЛЫН БҮЛЭГ



2016 оны байдлаар 50 МХБ, 800 гаруй гишүүдтэй, 9 газар Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбоо (МХБХ), Хамт Олныг Хөгжүүлэх Сангууд (ХОХС) үйл ажиллагаа явуулж байна.


МХБүлгүүдийн бүтэц




Хамт Олны Хөгжлийн Хөтөлбөр нь 2016 онд амжилт бүтээлээр арвин байлаа. Өвөрхангай, Дорнод, Дархан-Уул аймаг, Хэнтий аймгийн Хэрлэн, Мөрөн сум, Сүхбаатар аймгийн Дарьганга, Онгон, Наран сум, Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Улаанбаатар хотын МХБүлгүүдийн Холбоод хамт олны хүчээр өөрсдийн нөөц бололцоог ашиглан нийтлэг зорилготой олон шинэ санаачлага гарсаар байна. Бид гишүүдийг чадавхижуулах, хөгжүүлэхэд илүү их анхаарал тавьж ажилласны үр дүнд бүлгийн гишүүд орон нутгийн сонгуульд идэвхитэй оролцож багийн иргэдийн нийтийн хурлын дарга, тэргүүлэгч гишүүнээр сонгогдсон байна.

МХБ-ийн гишүүд тулгамдсан асуудлаа хамтдаа шийдвэрлэж, бие биенийгээ дэмжин урагшаа тэмүүлсээр байна. Тухайлбал, зохистой орон байраар хангагдах эрх, хүний эрхийн төлөө кампанит ажил, судалгаа, сургалт, туршлага солилцох уулзалтууд зохион байгуулж, гишүүдийн орон байрны нөхцлийг сайжруулах, амьжиргаа дээшлүүлэх олон төсөл хэрэгжүүлэн, хуримтлалаа өсгөхийн зэрэгцээ Хамт Олныг Хөгжүүлэх сангуудаа арвижуулахын төлөө ажилласаар байна.


МХБүлгүүдийн байрлал



Мөнгөн хуримтлалын бүлгүүдэд олгодог зээлийн төрлүүд



Мөнгөн хуримтлалын бүлгийг хөгжүүлэх хамт олны сангууд



Мөнгөн хуримтлалын бүлгүүдийн хэрэгжүүлсэн жижиг төслүүд

№	Төслийн хэлбэр	Санхүүжилт
1.	Блок	3,000,000
2.	Модон үйлдвэрлэлийн аж ахуйг өргөтгөх	2,000,000
3.	Гишүүдийн орон байрны нөхцөл сайжруулах	3,000,000
4.	Хүнсний ногоо тариалах	1,000,000
5.	Байшин засварлах	2,000,000
6.	Байшингийн дээвэр	2,000,000
7.	Хашаа төсөл	1,000,000
8.	Хадлангийн тоног төхөөрөмж авах	3,000,000
9.	Тоосго, блокны үйлдвэрлэл өргөтгөх	2,000,000
НИЙТ		19,000,000 төгрөг

Мөнгөн Хуримтлалын бүлгүүд, МХБХ-ны дэргэдэх Хамт Олныг Хөгжүүлэх Сангуудын хөрөнгийн нийлбэр дүн 67,331,600 төгрөг /\$33,666 \$/

Орон гэргүй, орон гэрийн нөхцөл тааруу, амьдралын төвшин доогуур бүлгийн гишүүдийг өөрсдөөр нь шалгаруулж дэмждэг хөтөлбөрийн нэг бол БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ юм.

Тус хөтөлбөрт Өвөрхангай, УБ, Дорнод, Хэнтий, Дархан-Уул аймгийн бүлгийн гишүүдийн 5 өрх хамрагдлаа. Тэд байшингийн дээвэр шинэчлэх, шинээр байшин барих, шинэ гэр авах, гэрийн дулаалга хийх зэргээр орон гэрээ сайжруулсан.



ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ӨДӨР:

Дэлхийн Эрүүл Мэндийн өдрийг тохиолдуулан ахмадын эрүүл мэндийн асуудлыг авч хэлэлцэн “Чихрийн шижингийн эсрэг тэмцье” өдөрлөгийг УБ хот, Өвөрхангай, Дорнод аймгийн МХБХ-д зохион байгууллаа. Өндөр настан хүмүүс нь өөрсдийн болон улс орны хөгжил дэвшилд идэвхтэй оролцогчид хэмээн хүлээн зөвшөөрөгдөх ёстой бөгөөд тэд зөвхөн халамж хүртэгч гэсэн ойлголтыг халж нийгмийн хандлагыг өөрчлөхийг хүсч илэрхийлж байсан юм.



ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨДӨРТ ЗОРИУЛЖ “УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ДАСАН ЗОХИЦОХУЙ” СЕМИНАР



Хүний Эрх Хөгжил Төв нь дэлхийн байгаль орчны өдрийг тохиолдуулан иргэний нийгмийн байгууллагууд болон малчдад зориулж “Уур амьсгалын өөрчлөлт ба дасан зохицохуй” сэдэвт сургалтыг 2016 оны 6 сарын 4-5-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Сургалтанд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд болон ХЭХТ-ийн дэргэдэх УБ хот, Өвөрхангай, Дархан-Уул, Дорнод, Хэнтий, Сүхбаатар зэрэг аймгуудын Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн Холбооны гишүүдийн төлөөлөл хүрэлцэн ирж оролцлоо.

Сургалтын сургагч багшаар Энэтхэг улсын иргэн Мадрасын Технологийн Их Сургуулийн Эрдэм шинжилгээний ажилтан, доктор Авилаш Рөүл ажиллаж “Уур амьсгалын өөрчлөлт, шалтгаан, үр дагавар”, “Монгол улсын уур амьсгалын өөрчлөлтийн хандлага ба түүнд дасан зохицох нь”, “Уур амьсгалын өөрчлөлтийн судлал ба гамшгийн хамаарал” сэдэвт илтгэлүүдийг тавин оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүллээ. Мөн “Хүнс Эвсэл” төрийн бус байгууллагын тэргүүн Г. Оюунтуяа “Монгол дахь уур амьсгалын өөрчлөлт ба түүний хор уршиг” сэдвээр илтгэл тавилаа.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН МӨНГӨН ХУРИМТЛАЛЫН БҮЛГҮҮДИЙН ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 10 ЖИЛИЙН ОЙ БОЛОН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ

Өвөрхангай аймгийн Мөнгөн Хуримтлалын Бүлгүүдийн үүсч хөгжсөний 10 жилийн ой болон Туршлага солилцох уулзалтыг 2016 оны 7-р сарын 20-24-ны хооронд Арвайхээр хотноо зохион байгууллаа. Тус ойн арга хэмжээ болон туршлага солилцох уулзалтанд нийт 160 гаруй төлөөлөгчид болон орон нутгийн удирдлагууд оролцож тулгарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг шийдэх арга замыг олох өөрсдийн амжилт, алдаа оноогоо дүгнэн, ололт амжилтаас бусадтайгаа хуваалцаж, бусдаас суралцах, харилцан туршлага солилцон, цаашид хамтран ажиллах зорилго, зорилтуудаа тодорхойлсон юм.





ХЭХТ-ИЙН ХАМТ ОЛОН, ХАМТРАГЧИД



ХАМГААЛАЛТЫН МЕХАНИЗМЫН АСУУДЛААРХ ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЁРДУГААР ЗӨВЛӨГӨӨН

Follow-up Workshop from National Human Rights Defenders (HRDs)
Consultation on Protection Mechanism



ХҮНИЙ ЭРХ ХӨГЖИЛ ТӨВ нь 2016 онд үндсэн ажилтан 7, гадны сайн дурын ажилтан 5, Нийтийн эрх ашгийн клиникийн 10 оюутан, дадлагажигч 3 хүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.

ХАМТРАН АЖИЛЛАГСАД

ХЭХТ үзэл баримтлал нэг үндэсний, бүсийн болон дэлхийн иргэний нийгмийн олон байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж, гишүүн дэмжигчээр ажилладаг.


ҮНДЭСНИЙ:

1. Хүнс Эвсэл - Хүнсний тусгаар тогтнолын төлөө ТББ-иудын эвсэл
2. Хүний эрхийн ТББ-иудын Форум
3. Хөгжлийн ажиглагч - Хөгжлийн үр нөлөөг сайжруулах ТББ-иудын эвсэл
4. Төлсөн авсанаа нийтэл (ТАН) Эвсэл
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ТББ-ын сүлжээ
6. МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ
7. Бүх нийтийн төлөө боловсрол эвсэл

ОЛОН УЛСЫН:

1. Форум-Ази (Азийн хүний эрх, хөгжлийн форум)
2. PANAP (Ази номхон далайн пестицид үйл ажиллагааны сүлжээ)
3. RoA (Зээл тусламжийн бодит байдал сүлжээ)
4. CPDE (Хөгжлийн үр нөлөөг сайжруулах иргэний нийгмийн түншлэл)
5. ANNI (Азийн хүний эрхийн үндэсний байгууллагын үйл ажиллагааг хянах сүлжээ)
6. IBON INT (ИБОН олон улсын байгууллага)
7. ADA (Азийн хөгжлийн эвсэл)
8. ACHR (Азийн орон байрны эрхийн эвсэл)
9. Help Age International (Насжилтад туслах дэлхийн сүлжээ)
10. APRN(Ази Номхон далайн судалгааны сүлжээ)

2016 ОНД ХЭВЛҮҮЛСЭН ТАРААХ МАТЕРИАЛ:



САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ БАЙДАЛ 2016 ОН

1 2016 оны орлого 1-ээс 12 сар

А	Доноруудаас	USD	Дүн /₮/	Эзлэх %
1	Гадаад Хэргийн Яам АСЕМ-ын бэлтгэл ажлын алба	76,807	157,300,200	50
2	Азийн хүний эрх,хөгжлийн форум	13,431	31,248,846	10
3	ХОХХ-ын Эргэлтийн сангаас	13,681	27,362,475	9
4	Азийн орон байрны эрхийн эвсэл	6,500	13,646,700	4
5	Asian House- АЕТЧ	6,392	13,250,616	4
6	Ази номхон далайн судалгааны сүлжээAPRN	5,137	12,575,376	4
7	Байгалийн нөөцийн засаглалын хүрээлэн	4,500	11,038,410	4
8	Даян дэлхийн ногоон сан	5,500	10,902,375	3
9	Насжилтад туслах дэлхийн сүлжээ	3,717	7,833,131	2
10	Европын холбоо- АЕТЧ	3,395	6,935,985	2
11	TNC	3,090	6,179,600	2
12	Хөгжлийн үр нөлөөг сайжруулах иргэний нийгмийн түншлэл	1,785	3,643,131	1
13	Азийн сан	400	800,000	0
14	SDC / Тогтвортой бичил уурхай/	225	450,000	0
В	Байгууллагын орлого			
1	Түрээсийн орлого	4,791	9,581,948	3
2	Хүүний орлого	377	754,002	0
3	Бүсгүйчүүл 21-р зуун ТББ/Хандив/	50	100,000	0
4	Б.Одгэрэл/Хандив/	45	89,720	0
	НИЙТ ДҮН	149,823	313,692,515	

2 Байгууллагын зардал

	Хөтөлбөр	USD	Дүн /₮/	Эзлэх %
1	Хүний эрхийн хамгааллын хөтөлбөр	22,236	44,472,977	13
2	Хүний эрхийн нөлөөллийн хөтөлбөр	81,787	163,574,046	49
3	Хамт олныг хөгжүүлэх хөтөлбөр	30,174	60,348,912	18
4	Захиргааны зардал	31,628	63,256,533	19
	Нийт дүн	165,826	331,652,468	100

3 2016 оны тайлан тэнцэл

	USD(\$)	MHT(₮)
2016 оны 1 сарын 1-ны эхний үлдэгдэл	41,929	83,647,965
Орлого	156,846	313,692,515
Зарлага	(165,826)	(331,652,468)
2016 оны 12 сарын 31-ны эцсийн үлдэгдэл	26,779	65,688,012